

## БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ЛАОС АРД УЛСАД БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦУУЛАХ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

### Нэг. Тавигдах шаардлага

- Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангид суралцдаг Монгол Улсын иргэн бол хөтөлбөрт өргөдөл гаргах жилд суралцаж буй хугацааны дүнгийн хуулбар 80+ буюу түүнээс дээш байх
- Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн 1, 2 дугаар ангид суралцагч Монгол Улсын иргэн бол голч дүн 3.0 ба түүнээс дээш голч дүнтэй байх
- Өөр улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх

### Хоёр. Суралцах мэргэжлийн чиглэл, хяналтын тоо:

- Сэргээгдэх эрчим хүч,
- Олон улсын харилцаа,
- Хууль,
- Эдийн засаг

Дээрх чиглэлээр бакалаврын түвшний сургалтад суралцуулах оюутны хяналтын тоо жил бүр харилцан адилгүй байх бөгөөд суралцах мэргэжлийн чиглэл ажлын байрны эрэлт хэрэгцээ шаардлагатай холбоотой жил бүр өөрчлөгдөх магадлалтай байдаг.

**Гурав. Бүртгэл:** Жил бүрийн III-IV сард явагддаг.

Бүртгүүлэхдээ <https://scholarship.esis.edu.mn/> холбоосоор хандан, хэрэглэгчийн эрх үүсгэн нэвтэрч, цахим өргөдлийг бөглөх, илгээх гарын авлагатай танилцан, өргөдлийг бөглөж илгээнэ. Өргөдөлд дурдсан дараах баримт бичиг тус бүрийг PDF /1 файлын хэмжээ 5Mb-аас ихгүй байх/ хэлбэрээр “баримт бичиг” хэсэгт хавсаргана.

### **Цахим бүртгэлийн системд байршуулах баримт бичиг:**

Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагч бол:

- Цахим өргөдөл
- Анги удирдсан багшийн тодорхойлолт;
- Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад Засгийн газрын тэтгэлгээр суралцах хүсэлтэй байгааг илэрхийлсэн эсээ /Монгол хэлээр 500 дээш үгтэй байх/;
- 11 дүгээр ангийн дүнгийн хуулбар;
- Сүүлийн 6 сарын хугацаанд авахуулсан 3\*4 хэмжээтэй цээж зураг цахимаар оруулна;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;

Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн I-II курст суралцаж буй иргэн:

- Цахим өргөдөл
- Сургуулийн тодорхойлолт;
- Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад Засгийн газрын тэтгэлгээр суралцах хүсэлтэй байгааг илэрхийлсэн эсээ /Монгол хэлээр 500 дээш үгтэй байх/;
- Сүүлийн семестрийн дүнгийн тодорхойлолт;

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Сүүлийн 6 сарын хугацаанд авахуулсан 3\*4 хэмжээтэй цээж зураг цахимаар оруулна.

Жич: Онлайн бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө бүртгүүлсэн баримт бичгийг **ИЛГЭЭХ** товчин дээр дарж баталгаажуулахыг анхаарна уу.

Бүртгэл дуусах цаг дөхөх тусам системийн ачаалал ихэсдэг тул эрт бүртгүүлэхийг зөвлөж байна.

Бүртгэлээс хоцорсон иргэдийг нэмж бүртгэх боломжгүй тул та тогтоосон хугацаанд бүртгүүлнэ үү.

**Цахим бүртгэлийн системд үнэн, зөв баримт бичгийг байршуулах шаардлагатай. Баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд тэтгэлгийн эрхийг хасна.**

### **Дөрөв. Сонгон шалгаруулалт**

Сонгон шалгаруулалт хоёр үе шаттай байна.

1. **Баримт бичгийн бүрдүүлэлт.** Тэтгэлэгт хөтөлбөр горилогчийн ирүүлсэн бичиг баримтын бүрдэл, эсээний агуулга, ач холбогдол, өөрийгөө илэрхийлсэн байдал зэрэгт үнэлгээ өгнө.
2. **Ярилцлага.** Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан сонгон шалгаруулалтын ярилцлагыг цахим хэлбэрээр хийнэ. Цахим ярилцлагын цагийн хуваарь, оролцох иргэдийн нэрсийн жагсаалтыг Боловсрол, шинжлэх ухааны яамны вебсайтад байршуулна.

Нийт сонгон шалгаруулалтад оролцсон иргэдийг баримт бичгийн бүрдүүлэлт, ярилцлагын нийлбэр оноогоор жагсааж, хамгийн өндөр оноо авсан иргэдэд тэтгэлэг олгоно.

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**